

**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР “ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2022.11.23

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон: Үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл (хувиар)
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4.1 Төсвийн ерөнхийлөн Захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангулна.							
1.1.1	Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй үр өгөөжтэй зарцуулж, төсвийн гүйцэтгэл, холбогдох мэдээ мэдээллийг шилэн дансны мэдээллийн сайгад байршуулах, төсвийн сахилга батыг чанд сахиж, өр авлага үүсгэхгүй ажиллах.	816,6	Шилэн дансны сайгад хугацаанд нь оруулсан мэдээний тоо	36	65	Энэ онд 816,6 сая төгрөгийн төсөв батлагдсан байснаас 2022 оны хагас жилийн төсвийн тодотголоор 617,8 сая төгрөг болж буурсан бөгөөд төсвийн 01–10 дугаар сарын гүйцэтгэл 494,9 сая төгрөгийг шилэн дансны мэдээллийн сайгад байршуулсан. "Шилэн дансны тухай" тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д зааснаар тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт болох 3-н мэдээ, жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотар мэдээлэх байсан боловч 2022 оны 04 дүгээр сард мэдээллэсэн мөн 04, 08, 09 дүгээр сарын 22 мэдээг хугацаа хоцорч мэдээллэсэн. Шилэн дансны http://www.shilendans.gov.mn сайтад 2022 оны 10 сарын байдлаар нийт 127 мэдээ оруулж тайлагнахаас хугацаанд нь 102 мэдээг байршуулсан. Санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж 2022 оны 01-10 сарын төсвийн гүйцэтгэл 494,9 сая төгрөгийн мэдээг	90%

							Нийслэлийн төрийн санд хургуулж ажиллалаа.	
1.2 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.2.1 Төрийн албан хаагчийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, авлига хээл хахууль авсан гэмт хэргийн тоог бууруулна								
1.2.1	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад ажилтнуудыг хамруулж, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд өгүүлсэн байна.		Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо, хөрөнгө орлогын мэдүүлэг өгсөн тоо	25	30		Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хамтран 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр зохион байгуулсан "Авлигын эсрэг нийслэлийн зөвлөгөөнд" Орлогч дарга хамрагдаж, байгууллагын 25 ажилтан, албан хаагч наарт тус зөвлөгөөний талаар мэдээлэл өгч, "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Байгууллагын Газрын дарга, орлогч дарга, Нягтлан бодогч гэсэн 3-н ажилтан, албан хаагч, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж хүргүүлсэн. Авлигын эсрэг хуулийн талаарх 5 мэдээллийг бэлтгэн байгууллагын албан ёсны веб сайтад байршуулж, түгээн дэлгэрүүлж сурталчилсан. Энэ оны байдлаар байгууллагын хэмжээнд авлига, хээл хахууль, гэмт хэрэгтэй холбогдсон ажилтан, албан хаагч бүртгэгдээгүй байна.	90%
1.3 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4 Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана.								
1.3.1	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу байгууллагын ил тод байдлыг хангаж ажиллах		Ил тод байршуулсан мэдээ мэдээллийн тоо	135	200		"Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль", Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам", Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт" зэрэг хууль журмыг нийт ажилтан, албан хаагч наарт танилцуулсан.	100%

<p>Байгууллагын ил тод байдлыг хангаж ажиллахыг мэдээлэл технологийн ажилтан, нягтлан болон архитекторч нарын ажлын байрны тодорхойлолтод тусган ажиллаж байна. Газрын даргын баталсан А тушаал, ажилд шинээр томилогдсон, ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын 4-н мэдээллийг байгууллагын веб сайтад байршуулсан. Мөн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, иргэд олон нийтэд таниулах, цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор нийт 115 мэдээ мэдээлэл, байгууллагаас болон бусад хамтран ажилладаг газруудаас зарлагдсан аяны 11 мэдээ мэдээллийг веб сайт, цахим хуудсанд, "Монгол наадам" гэр баазын пэйж хуудсанд нийт 28 мэдээ мэдээлэл байршуулсан. Ажлын байрны 10-н зарыг байгууллагын пэйж хуудас болон бусад, зарын группуудэд нийт 8-н удаа оруулсан. Сонгинохайрхан дүүргийн Хедэлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн нийт 42 хороодын зар байршдаг группдэд 5 удаагийн 11-н төрлийн зарыг албан ёсны загварын дагуу бэлтгэн байршуулсан бөгөөд давхардсан тоогоор нийт 185 мэдээг ил тод байршуулж ажиллалаа. Мөн www.shilendans.gov.mn сайтад холбогдох хуулийн дагуу санхүүгийн мэдээллийг байршуулж ажилласан.</p>								

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

2.1.	Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг баталж мөрдүүлэх	Хөтөлбөрийн тоо	-	1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулагддаг албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх 18 удаагийн сургалтад сургалтын хөтөлбөрийн дагуу 18 ажилтан, албан хаагч, мөн ажлын байранд зохион	100%
------	---	-----------------	---	---	--	------

						байгуулсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, ёс зүйн талаарх З удаагийн сургалтад 35 ажилтан албан хаагч тус тус хамрагдсан. Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулсан Газрын даргаар батлуулж албан хаагчдад танилцуулсан.	
2.2.	Хүний нөөцийн холбогдолтой судалгаа, тоо бүртгэл, хувийн хэргийн бүрдлийг хангаж жилийн эцсийн байдлаар тайлан гаргах		Тайлан гаргасан тоо	2	4	Байгууллагын хүний нөөцийн холбогдолтой судалгааг холбогдох маягт, загварын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хетлех журам"-ын дагуу албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг хантан ажиллаж байна. Байгууллагын 38 ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг улирал тутам шинэчилж, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, цаг бүртгэл, өргөдөл гомдлын шийдвэрлэлт тэсэн 3 тайланг хугацаанд нь гаргаж ажилласан.	90%
2.3.	Хүний нөөцийг төлөвлөх, судлах, сонгох, томилох, чөлөөлөх санал боловсруулан танилцуулах, шийдвэрийн төсөл боловсруулах		Санал боловсруулсан тоо, шийдвэрийн төслийн тоо	83	83	Хүний нөөцийг томилох, чөлөөлөх талаар Б тушаалын шийдвэрийн төсөл боловсруулж хянуулан, 82 тушаалыг газрын даргаар баталгаажуулан тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	90%
2.4.	Хүний нөөцийн асуудлаар санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч барагдуулахад дэмжлэг үзүүлэх		Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо	28	30	Байгууллагын ажилтан, албан хаагчдаас нийт 56 өргөдөл гомдол, санал, хүсэлт ирснийг холбогдох хууль, журмын дагуу 100 хувь шийдвэрлэн ажиллаж байна.	100%

2.5.	Ажлын байрны зураг авалт, шинжилгээ хийх ажлыг зохион байгуулна.		Зураг авалт, шинжилгээ хийсэн тоо	1	2	Ажлын байрны зураг авалтыг жилийн эцсийн байдлаар нийт 10 ажилтанд хийсэн.	100%
2.6.	Албан тушаал бүрийн процессын зураглал гаргаж батлуулах		Процессын зураглал гаргасан албан тушаалын тоо	-	20	Байгууллагын 23-н ажилтан, албан хаагчдын процессын зураглал гаргаж Газрын даргаар батлуулсан.	100%
2.7	Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлж ажилтан албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг шинэчилж байгуулах		Хөдөлмөрийн гэрээ байгуулсан ажилтны тоо	-	39	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн байгууллагын 38-н ажилтан, албан хаагчидтай Хөдөлмөрийн гэрээ байгуулж 2% үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулан ажилтны хувийн хэргийн бүрдэлд авч ажиллаж байна.	100%
2.8	Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлж ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэх		Ажлын байрны тодорхойлолт шинэчлэн боловсруулсан тоо	-	24	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01.01-ны өдрөөс мөрдөгдэж эхэлсэнтэй холбогдуулан нийт 23-н албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан. Ажлын байрны тодорхойлолтын дагуу байгууллагын гэрээ, тушаал шийдвэрүүдэд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хяналт тавьж алдаа дутагдлыг тухай бүр засаж залруулан ажиллаж байна.	100%
2.9	Нийт ажилтнуудын ажлыг сар, улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэж, цалин хэлс, урамшууллыг олгох.	602,7	Ажил дүгнэж, цалин урамшуулал олгосон хэмжээ /сая төгрөгөөр /	417,6	602,7	Нийт ажилтан албан хаагчдад 2022 оны 01 дүгээр сараас 2022 оны 10 дугаар сарыг дуустал цалин хэлс болон нэмэгдэл урамшууллын 353,3 сая төгрөгийг олгосон. Цалингийн санд 602,7 сая төгрөг төсөвлөгдсөн байсан бөгөөд хагас жилийн төсвийн тодотголоор 424,3 сая төгрөг болж	100%

						буурсан. 11,12 дугаар сард үлдсэн төсвийг зарцуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
2.10	Ажилтнуудын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлж, нийгмийн үйлчилгээ авах боломжийг хангах.	81,3	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал төлсэн хэмжээ	55,1	81,3	Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалыг 2022 оны 01 дүгээр сараас 10 дугаар сарыг дуустал 56,9 сая төгрөгийг хуулийн хугацаанд төлж нийгмийн үйлчилгээ авах боломжийг ханган ажиллаж байна. Хагас жилийн тесвийн тодотголоор 61,0 сая төгрөг болж буурсан бөгөөд үлдэгдэл тесвийг 11,12 дугаар сард ажилчдын эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлөхөөр төлөвлөж байна.	90%
2.11	Ажилтнуудын хэвийн таатай орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх, түрээс, цэвэр бохир усны өр авлагагүй ажиллах.	42,2	Байр ашиглалттай холбоотой зардлыг бүрэн санхүүжүүлсэн хэмжээ /сая. төгрөгөөр /	37,5	42,2	2022 оны 03 дугаар улирлын байдлаар байр ашиглалттай холбоотой гарсан 30,1 сая төгрөгийн зардлыг тухай бүрт нь төлж өр авлагагүй ажиллаж байна.	100%
2.12	Ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах, ХАБЭА-н зөрчилгүй ажиллах.	1,3	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	0,7	1,3	Ажилтан, албан хаагчдыг 0.7 сая төгрөгийн хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангаж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөрчилгүй ажиллаж байна. Төсвийн тодотголоор зардлын анпилал өөрчилж 0,7 сая төгрөгийг 2,2 сая төгрөг болгосон бөгөөд тайлант он дуусталх хугацаанд зарцуулан ажиллана.	90%
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛИЙН ХҮРЭЭНД ЯВУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
3.1.	Газрын даргын А, Б тушаалын төслийг хянаж, хууль эрх зүйн актад нийцүүлэх		Хянасан тушаалын тоо	120	120	2022 оны жилийн эцсийн байдлаар газрын даргын 34А тушаал, 82Б тушаалын хуулийн үндэслэл, агуулга, найруулга зүйг хянан хууль эрх зүйн актад нийцүүлэн гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70%

3.2.	Ажил гүйцэтгүүлэх, Худалдан авах болон Эд материалын түрээсийн гэрээний эхийг бэлтгэн гэрээ хийх		Байгуулсан гэрээний тоо	21	21	Газрын хэмжээнд хийгдэх гэрээнүүдийн загварыг шинэчилж эхний 10 сарын байдлаар Ажил гүйцэтгэх гэрээ -23, Газар ашиглуулах гэрээ-6, Түрээсийн гэрээ-19, Хамтран ажиллах гэрээ -2, Худалдах, худалдан авах гэрээ-12, Худалдаа, үйлчилгээ үзүүлэх гэрээ-51, Хөлсөөр ажиллуулах гэрээ-69, Утас интернэт, ашиглах гэрээ-3 нийт 185 гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.	100%
3.3.	Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлж байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлуулж мөрдүүлэх		Батлуулсан дотоод журмын тоо	1	1	Байгууллагын хөдөлмөрийн дотаод журмыг оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн A/01 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.	100%
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫГ ХУУЛИЙН ХҮРЭЭНД ЯВУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
4.1.	Газарт хамаарах бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн тайлагнах, хяналт шинжилгээ үнэлгээ хийх календарьчилсан хуваарь, дотоод хяналтын ажлын дэд төлөвлөгөө гаргаж, газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж батлуутах		Төлөвлөгөө боловсруулсан тоо	1	1	Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх журмыг шинэчлэн газрын даргын 2022 оны A/12 тушаалаар батлуулж мөрдөн ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагаанд болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх календарьчилсан хуваарийг 33 заалттайгаар, мөн 12 заалт бүхий дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд төлөвлөгөө 100 хувийн биелэлттэй хэрэгжсэн.	100%

4.2.	Газарт хамаарах бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд батлагдсан графикийн дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, даргын зөвлөлийн хуралд танилцуулах, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанад тайлагнах		Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	1	4	Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 3 арга хэмжээний биелэлт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 3 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, даргын зөвлөлийн хуралд танилцуулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүр гүүлэхээр ажиллаж байна.	100%
4.3.	Газарт хамаарах “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт”-д хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөмж өгөх, газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулах		Өгсөн зөвлөмжийн тоо	1	4	Газарт хамаарах 1 хуулийн 5 заалт, Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 1 заалт, Засгийн газрын 6 тогтолын 10 заалт, Засгийн Газрын 1 хуралдааны тэмдэглэлийн 3 заалт, Засгийн газрын 1 албан даалгаврын 2 заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 1 тушаалын 2 заалт, Засгийн газрын хуралдааны 1 тэмдэглэлийн 2 заалт зэрэг нийт холбогдох 12 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 25 заалтын биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд хяналтад авсан 25 заалтын 23 нь бүрэн хэрэгжсэн буюу 90-100 хувийн үнэлгээтэй, 2- заалт хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн ба биелэлтийн дүн дунджаар 94.4 хувьтай үнэлэгдсэн. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэхээр 6 заалт бүхий зөвлөмжийг өгч ажиллалаа.	90%
4.4.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хянаж, ажлуудыг бүрэн тусгуулах, уялдаа холбоог		Авсан арга хэмжээний тоо	-	3	Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 бүлэг зорилтын хүрээнд 66 арга хэмжээ тусгагдсан байдлаар хянаж, батлуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд	100%

	хангуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах					Улаанбаатар хотын захирагчтай байгуулах Хариуцлагын гэрээнд хавсралтаар оруулж батлуулсан	
4.5.	Газрын жилийн “Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох арга хэмжээ авах		Зөрчил арилгуулсан тоо	-	2	Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж 2022 оны хагас жилаэр хэрэгжилтийг бүрэн хангах талаар З заалт бүхий зөвлөмжийг өгч ажиллав. Тайлант оны 11 дүгээр сарын байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөө 93,9 хувийн биелэлтэй хэрэгжсэн байна.	90%
4.6.	Албадуудад батлагдсан удирдамж, хуваарийн дагуу Газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Газрын даргын тушаалын хэрэгжилтэд хяналт шалгалт явуулж, даргын зөвлөлийн хуралд танилцуулах, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх		Зөрчил арилгуулсан тоо	1	2	Энэ оны 11 дүгээр сарын байдлаар Газрын даргын зөвлөлийн 6 хурлын шийдвэр, хүний нөөцтэй холбогдол бүхий 82Б тушаал, байгууллагын үйл ажиллагаатай холбогдол бүхий 34А тушаал тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шалгалт явуулж даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллаа. Хагас жилийн хяналт шалгалтаар Газрын даргын тушаалын хэрэгжилтэд илэрсэн З зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.	90%
4.7.	Газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд сэдэвчилсэн байдлаар хяналт, шалгалтыг хэрэгжүүлж, дүгнэлт, саналыг даргын зөвлөлийн хуралд танилцуулах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх		Зөрчил арилгуулсан тоо	1	2	Шилэн дансны тухай хуулийн дагуу 2022 оны 1–10 сарын төсвийн гүйцэтгэлийг шилэн дансны мэдээллийн сайтад байршуулсан байдалд хийсэн дотоод хяналт шалгалт хийхэд http://www.shilendans.gov.mn сайтад 2022 10 сарын байдлаар 127 мэдээ байршуулахаас хугацаанд нь 102 мэдээг оруулж тайлагнасан байна. “Шилэн дансны тухай” тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д зааснаар тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт болох З-н	90%

							мэдээ, жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэх байсан боловч 2022 оны 04 дүгээр сард мэдээллэсэн мөн 04, 08, 09 дүгээр сарын 22 мэдээг хугацаа хоцорч мэдээллэсэн зөрчил гарсан.	
4.8.	Баримт бичгийн стандартын хэрэгжилт, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлж, даргын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох арга хэмжээ авах		Зөрчил арилгуулсан тоо	3	6	Байгууллагад ирсэн явсан бичгийн тайланг 14 хоног тутамд тогтмол гаргаж байгаа байдалд болон байгууллагаас явуулсан нийт 145 албан бичигт хяналт тавьж ажилласан. 11 сарын байдлаар нийт 192 албан бичиг ирснээс 189 албан бичгийг шийдвэрлэж; 3 бичгийг судалж байна. Албан бичиг шийдвэрлэлтийг хувь 98%. Шийдвэрлэлтийн дундаж 6 хоног байна. 2021 оны ХХНЖ-д тусгагдсан 35 баримтуудыг архив зүйн дагуу бүрэн зөв тусгаж ангилан төрөлжүүлсэн байдалд хяналт тавьж ажилласан бөгөөд зохион байгуулалтын нэгж, ажилтнууд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтуудыг ангилан төрөлжүүлж, байгууллагын архивт 1 дүгээр улиралд багтаан хүлээлгэн өгсөн байна.	90%	
4.9.	Хариутай бичгийн шийдвэрлэлт, erg.ulaanbaatar программын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 2, 5, 6 дугаар сард 3 бичгийг хугацаандаа шийдвэрлэсэн ч тус бичгүүдийг edoc программд хугацаа хэтэрч хаасан байна. Байгууллагын архивын үйл ажиллагаанд https://arch.ulaanbaatar.mn/ программын хемрөг, данс, хадгаламжийн нэгж, баримт, нөхөн бүрдүүлэлт; хяналт дэд цэсүүдээр дамжуулан байгууллагын архивын цаасан суурьт баримтыг цахим тоон хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна. Одоогийн		Зөрчил арилгуулсан тоо	4	8	Erg.ulaanbaatar программын edoc цэсний үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 2, 5, 6 дугаар сард 3 бичгийг хугацаандаа шийдвэрлэсэн ч тус бичгүүдийг edoc программд хугацаа хэтэрч хаасан байна. Байгууллагын архивын үйл ажиллагаанд https://arch.ulaanbaatar.mn/ программын хемрөг, данс, хадгаламжийн нэгж, баримт, нөхөн бүрдүүлэлт; хяналт дэд цэсүүдээр дамжуулан байгууллагын архивын цаасан суурьт баримтыг цахим тоон хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна. Одоогийн	100%	

						байдлаар https://arch.ulaanbaatar.mn/ программд газрын даргын 2013-2021 оны захирамжлалын баримт бичгүүдийг оруулан нягтлан шалгаж, Нийслэлийн архивын газраар батлан шалгуулж ажиллаж байна.	
4.10.	Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын гүйцэтгэл үр дүнг хэлэлцүүлэх	Зэрчил арилгуулсан тоо	-	2	Байгууллагын дүрмийн дөрөвдүгээр бүлгийн удирдлага зохион байгуулалтын 4.10.5-д тусгагдсан ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн пэрээ байгуулах, цалингийн урамшуулалт олгох журмын хэрэгжилт болон шилэн дансанд сар бүр мэдээлэл оруулж буй байдал, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдал, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого зохион байгуулах зэрэг үйл ажиллагааны хэрэгжилтэд төлөвлөгөө, хуваарийн дагуу хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл үр дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажиллаж байна.	90%	
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АРХИВЫН АЖЛЫГ СТАНДАРТЫН ДАГУУ ХӨТЛӨН ЯВУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
5.1.	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавих	Хяналт тавих тоо	24	24	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", "Журам шинэчлэн батлах тухай", "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр" Монгол улсын Цахим гарын үсгийн тухай хууль, "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам" "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх татаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" зэрэг эрх зүйн баримт	100%	

						бичгүүдийг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн, 11 дүгээр сарын байдлаар https://edoc.ulaanbaatar.mn/ программаар байгууллагад ирсэн 192, байгууллагаас явуулсан 145 албан бичгийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	
5.2.	Байгууллагад гаднаас ирсэн албан бичгийг бүртгэн авч удирдлагад танилцуулах, хуваарилах		Хяналтад авсан ирсэн бичгийн тоо	182	182	Байгууллагад 2022 оны 11 сарын байдлаар харилцагч байгууллагаас https://erp.ulaanbaatar.mn/ программаар хариутай 66, хариугүй 126 нийт 192 албан бичиг ирснийг бүртгэн шилжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан бөгөөд хугацаа хэтэрсэн болон шийдвэрлээгүй зөрчилтэй албан бичиг байхгүй байна.	100%
5.3.	Явуулсан баримт бичгийн үлдэх хувийг ангилан төрөлжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллах		Ангилан төрөлжүүлсэн явуулсан баримт бичгийн тоо	125	125	Тайлант оны 11 сарын байдлаар нийт 145 албан бичгийг Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр харилцагч байгууллагуудад илгээж, тохи гарын үсгээр баталгаажсан үлдэх хувийг хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулан ангилан төрөлжүүлж ажилласан.	100%
5.4.	Байгууллагын албан боловсруулсан бичгийг байгууллагад программаар жүргүүлэх ажилтан, хаагчдын албан, холбогдох eDoc		eDoc программаар хүргүүлсэн бичгийн тоо	125	125	Байгууллагын ажилтан, албан хаагчдаас хариутай 12, хариугүй 133 нийт 145 албан бичиг явуулсан байна. Үүнээс 128 албан бичиг нь Захиргаа, санхүүгийн албанаас, 16 албан бичиг нь Маркетингийн албанаас, 1 албан бичиг нь Тохижилт үйлчилгээний албанаас төлөвлөн https://erp.ulaanbaatar.mn/ программаар тус тус хүргүүлж ажилласан байна.	100%

5.5.	Байгууллагад ирсэн, явсан бичгийн тайланг тогтмол гаргах		Тайлан гаргасан тоо	4	4	Байгууллагад ирсэн, байгууллагаас явсан бичгийн тайланг 14 хоног тутамд тогтмол гарган удирдлагад тайлалтадаг бөгөөд 11 сарын байдлаар нийт 192 албан бичиг ирснээс 189 албан бичгийг шийдвэрлэж 3 бичгийг судалж байна. Албан бичиг шийдвэрлэлтийг хувь 98%, шийдвэрлэлтийн дундаж 6 хоног байна.	100%
5.6.	Албан хаагчдаас архивын материалыг ХХНЖК-ын дагуу хүлээн авах, данс бүртгэл үйлдэх		Хүлээн авсан архивын нэгж баримтын тоо	46	46	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны архивын 35 баримтыг нэгдүгээр улиралд багтаан ажилчдаас авч данс бүртгэлийг үйлдэж байнга, түр, 70 жилээр ангилан төрөлжүүлэн архивд хүлээн авсан.	100%
5.7.	Байгууллагын А, Б тушаалыг цахим архивлалт хийн нягтлан шалгаж ажиллах		Цахим архивлалтад хийсэн тушаалын тоо	149	117	Нийслэлийн Засаг даргын 2013 оны A/452 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хурээнд 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын А-38, Б-83 нийт 121 баримт бичгүүдийг цахим хэлбэрт шилжүүлэн байгууллагын архивын <i>Archive edoc</i> системд хөрвүүлэн нягтлан шалгаж, цахим нөхөн бүрдүүлэлтийг хуваарийн дагуу хийж гүйцэтгэн цахим хувийг тусгай тээгчид буулган Нийслэлийн архивын газарт хүлээлгэн өгчakt бүртгэлийг хүлээлцсэн.	100%
5.8.	Баримт нягтлан шалгах зөвлөлийн хурлыг журмын дагуу зохион байгуулж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулах		Хурлаар шийдвэрлэсэн асуудлын тоо	1	2	2022 онд Баримт нягтлан шалгах комисс 04, 06, 10, 11 дүгээр сард 4 удаа хуралсан бөгөөд БНШК-ын 01 дүгээр хурлаар “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлах, баримтын бүрэн бүтэн байдлыг авч хэлэлцэх тухай”, 02 дугаар хурлаар “Архивын баримтын данс бүртгэлийг батлах тухай”, 03 дугаар хурлаар “Цахим данс бүртгэлийг батлах тухай” 04 дүгээр хурлаар “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад санал авах	100%

						тухай" асуудлыг тус тус хэлэлцэж, хурлын шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажилласан.	
5.9	Албан хэрэг хөтлөлтөд шаардагдах бичиг хэргийн зардлыг бууруулах арга хэмжээ авах	1,5	Бичиг хэргийн зардлын хэмжээ	2,9	1,5	Тайлант оны 10 дугаар сарын байдлаар 1,1 сая төгрөгийг бичиг хэргийн материалын зардалд зарцуулсан бөгөөд үлдэгдэл төсвийг 11,12 дугаар сард зарцуулахаар төлөвлөж байна.	100%
ЗУРГАА. НЯГЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:							
6.1.	Шатахууны тайланг сар бурийн 05-ны дотор программд орлого зарлагыг авч тооцоо нийлсэн акт бэлтгэх	.	Тооцоо гаргасан тоо	12	12	Байгууллагын 2022 оны төсөвт нийт 29,0 сая төгрөгийн шатахууны зардал төлөвлөгдсөн бөгөөд үүнээс эхний 10 сарын байдлаар 20 сая төгрөгийн шатахууны зардал гарсан байна. Шатахууны тооцоо нийлэн актыг сар бүр гаргаж, шатахууны орлого зарлагыг дараа сарын 05-ны өдрийн дотор санхүүгийн программд гүйлгээ хийдэг бөгөөд 11 сарын шатахууны тайланг дараа сарын 05-ны дотор гарахаар төлөвлөн ажиллаж байна.	100%
6.2.	Улсын болон тэмдэглэлт ойн баяр наадам бусад тэмцээн арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой засвар үйлчилгээний, үнийн судалгаа хийх төсөв боловсруулах /задаргаатай /	.	Боловсруулсан төсвийн тоо, түүний хэрэгжилт хувиар	1	3	Улсын их баяр наадмын тохижилт үйлчилгээний засварын 20 нэр төрлийн төсвийг тус бүр задаргаатай нь төсөвлөн бэлтгэж НЭДТГ-т албан бичгээр хүргүүлсэн. Хүй 7 худагт зохион байгуулагдсан 11 арга хэмжээ, хөрөнгө түрээсийн 23 үнийн саналыг боловсруулж холбогдох байгууллагад танилцуулан гэрээ байгуулж ажиллав.	100%
6.3.	Байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөлийг улиралд 1 удаа хуралдуулах шаардлагатай үед хяналтын тооллого хийх гарсан шийдвэрийг тухай бүрт нь танилцуулж тайлагнах	.	Хурлаар шийдвэрлэсэн асуудлын тоо	4	6	Байгууллагын дэргэдэх өмч хамгааллын зөвлөл нь нийт 4 удаа хуралдаж өмч хамгаалах зөвлөлийн 2022 оны хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулсан. Улсын үзлэг тооллоготой холбоотойгоор байгууллагад хяналтын тооллого хийж хурлаас гарсан шийдвэрийг тухай бүрт нь танилцуулан тайлагнаж ажилласан. Газрын даргын 2022 оны А/32	100%

						дугаар тушаалаар 09 сарын 07-нд аж ахуйн нярав Батцэцэгийн ажлыг хүлээлцсэн. Нийт 2,5 тэрбум төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг аж ахуйн нярав Чонцолдууламд шилжүүлсэн. Газрын даргын 2022 оны А/33 дугаар тушаалаар 10.18-10.28-ны хооронд байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материал тоолох, дахин үнэлэх, актлах хөрөнгийн жагсаалтыг гаргах, үндсэн хөрөнгийг шинэчлэн кодлох үүрэг бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр тооллогын комиссыг томилж, тооллогын ўйл ажиллагааг зохион байгуулсан. Байгууллагын 539 ширхэг бараа материалын тооллогыг хийж, 366 ширхэг үндсэн хөрөнгийг шинээр дахин коджуулсан. Актлах шаардлагатай 13 нэр төрлийн 38ш үндсэн хөрөнгө, 31 нэр төрлийн 39ш зарлагадах шаардлагатай 8,926,049 төгрөгийн бараа материалын жагсаалтыг гаргаж нэгдсэн сан үүсгэсэн.	
6.4.	2022 оны улирал, хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан гаргах		Тайлан гаргасан тоо	4	4	2022 оны 01 дүгээр улирал, хагас жил, 03 дугаар улирлын санхүүгийн тайлант гарган санхүү, төрийн сангийн хэлтэст хянуулан албан бичгээр хүргүүлсэн. Санхүүгийн тайланд зөрчил илрээгүй байна.	90%
6.5.	2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдэх аудитын шалгалтад бэлтгэх, аудитын төлбөрийг төлөх	8,5	Бэлтгэл хангалтын хувь	50%	100%	2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдэх аудитын шалгалтад бэлтгэн аудит хийлгэсэн бөгөөд аудитын төлбөр 3.5 сая төгрөгийг Нийслэлийн Төрийн Аудитын газарт шилжүүлсэн.	100%
6.6.	2022 оны цалингийн программ, санхүүгийн программыг шинэчлүүлэн сар бүрийн төсвийн		Гүйцэтгэлийн хувь	50%	100%	2022 оны цалингийн программ, санхүүгийн программыг шинэчилж 01-12 дугаар сарын төсвийн төлөвлөгөөний хуваарийг программд шивсэн.	100%

	төлөвлөгөөний хуваарийг программд шивж оруулах						
ДОЛАО. БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
7.1.	Монгол наадам цогцолборын Ерөнхий төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран Засгийн газраар батлуулах		Төлөвлөгөө батлагдан эсэх	-	1	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 99 дугаар тогтооюур “Монгол наадам үндэсний цогцолбор”-ын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн баталсан	100%
7.2.	2022 оны байгууллагын бизнес төлөвлөгөө, орлого бүрдүүлэлтийн төлөвлөгөөг гаргаж, Нийслэлийн төсөвт орлого бүрдүүлэх	85,0	Батлуулсан төлөвлөгөөний тоо	2	3	Байгууллагын 2022 бизнес төлөвлөгөө, орлого бүрдүүлэлтийн төлөвлөгөөг гаргаж батлуулсан. Эхний 10 сарын байдлаар 140 сая төгрөгийн төсөв бүрдүүлээд байна. Орлого бүрдүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт 164,7 %-тай байна.	100%
7.3	“22 ШИНЭ САНАА” төслийг хэрэгжүүлэх Ажлын хэсэг, Төслийн багийн хийх ажлын төлөвлөгөөг хариуцах албан хаагч, албадтай хамтран батлуулах		Батлуулсан төлөвлөгөөний тоо	2	10	“Шинэ гэр”, “Үржлийн адууны дуудлага худалдаа”, “Мод үргүүлэг”, “Cap синема” зэрэг төслийдийг боловсруулж батлуулсан. Төслийдийг хэрэгжүүлэх талаар 2 байгууллагатай санамж бичиг байгуулав. Үржлийн адууны дуудлага худалдаа зохион байгуулахад оролцож ирээгүй.	70%
7.4.	“Монгол Наадам” Гэр баазын үйл ажиллагааг эрчимжүүлэх, гадна дотно тохижилтыг сайжруулах, стандарт зэрэглэлийг нэмэх, нэмэлт аялал амралтын хөтөлбөртэй болох		Хийгдсэн ажлын тоо,чанар	0	4	“Монгол Наадам” гэр баазын үйл ажиллагааг эрчимжүүлах, стандарт зэрэглэлийг нэмэгдүүлэх зорилгоор гэр баазын караокены төхөөрөмжийн шинэчлэлтийг хийсэн. Төсвийн хэмнэлтийн хуулиар шинээр эд хогшил худалдан авах, засвар хийх төсөв батлагдаагүй тул тохижилтын ажлууд хийгдээгүй. Гэр баазын үйл ажиллагааг эрчимжүүлж 6,2 сая төгрөгийн орлого	70%

						бүрдүүлсэн нь өнгөрсөн онтой харьцуулах 3 дахин ессөн үзүүлэлт юм.	
7.5.	2022 онд тэмдэглэлт баяр, тэгш ой тохиож буй төрийн болон төрийн бус байгууллага аж ахуй нэгжийн судалгаа гаргах, баяр наадам зохион байгуулах бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн санал хүргүүлж ажиллах		Хамтран ажилласан байгууллагын тоо	-	5	2022 онд тэгш ой тохиож буй 21 аймаг, 21 төрийн болон төрийн бус байгууллагуудын судалгааг гаргаж, баяр наадам зохион байгуулах бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн судалгааг гаргаж ажилласан. Хүй 7 худагт аж ахуйн нэгж байгууллагудтай хамтран 5 арга хэмжээг зохион байгуулж 11,6 төгрөгийн орлого бүрдүүлсэн.	100%
7.6.	2022 онд Мэргэжлийн болон Үндэсний спорт хороодын Хүй долоо худагт зохион байгуулах тэмцээн уралдааны тов гарган зохион байгуулах		2022 оны 08 сард Үндэсний спортын 7 дугаар их наадам, Даншиг наадам хүрээ цам	1000	1500	Мэргэжлийн болон үндэсний спортын холбоодтой хамтран Хүй долоон худагт 4 арга хэмжээг амжилттай зохион байгуулыг 49,3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Эдгэр арга хэмжээнд давхардсан тоогаар 7200 хүн оролцсон.	100%
7.7.	Монгол Наадам Цогцолбор ОНӨТҮГ газрын Улсын тусгай хэрэгцээний газрын 11.089г га газрын ашиглалтын байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах		Зөрчил арилгуулсан тоо	-	5	Улсын тусгай хэрэгцээний газрын 11.089 га газрын хилийн цэсийн тэмдэглэгээ шонг 2 удаа шалтаж эвдрэлтэй 1 шонг сэргээн засварласан. Зөвшөөрөлгүй орж ирсэн малчдын судалгааг гаргаж СХД-ийн газрын алба, цагдаагийн 1 дүгээр хэлтэст албан бичиг хүргүүлж зөрчил арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.	100%
7.8.	Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 11.2 км авто замд зорчих хөдөлгөөнд хяналт тавьж хуулийн хүрээнд татвар хураамж авч байгууллагын хөрөнгөнд бүрдүүлж болох талаар судалгаа хийх		Татвар хураамж авах эрх зүйн орчныг бүрдүүлсэн эсэх	0	1	Автозамын төлбөр хураамжийн эрх зүйн байдлыг судалж үзсэн. Авто замын төлбөр авах асуудлыг хуулиар зохицуулах бөгөөд төлбөрийн хэмжээг НИТХ-аас тогтоох эрхтэй болохыг судалж саналаа хүргүүлэхээр бэлтгэж байна.	30%

7.9.	Үндэсний Их Баяр наадам бусад томоохон баяр наадмын үеэр Хүй долоо худагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, худалдаачид, Уяачдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулан 127 дугаар тогтоолоор батлагдсан журмын хүрээнд холбогдох татвар хураамжийг авч төрийн сангийн дансанд оруулах		Бүрдүүлсэн орлогын хэмжээ / сая төгрөгөөр /	5,0	10,0	Ардын хувьсгалын 100,101 жилийн ойн их наадмын өдрүүдэд Хүй долоон худагт худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах 51 иргэн, аж ахуйн нэгжтэй "Худалдаа үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулж 10,6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Баяр наадмын өдрүүдэд үүрийн телефоны оператор компаниуд болон аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулж нийт 43,6 сая төгрөгийн орлого бүрдүүлэв.	100%
НАЙМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖКРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
8.1.	Нийслэлийн Соёл урлагийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар гэх мэт ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг Нийслэлийн харьяа байгууллагатай хамтран ажиллах, олон нийтийн зориулсан соёл урлаг, арга хэмжээ зохион байгуулах		Арга хэмжээний орлого (сая төг)	0	15,0	Нийслэлийн соёл урлагийн газар, аялал жуулчлалын газруудаас зохион байгуулсан Хөл бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээн, Сүүн зам соёлын наадам, Олон улсын морьт харвааны тэмцээнүүдэд гэрээний дагуу сандал ашиглуулж хамтран ажилласан. Эдгээр арга хэмжээнээс төсөвт 12,1 сая төгрөг төвлөрүүлэв.	90%
8.2.	"22 ШИНЭ САНАА" төсөлтэй холбогдолтой төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулах, төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах.		Санамж бичгийн тоо	0	5	2022 он-22 шинэ санаа төслийн хүрээнд Монголын Морин тойруулга богино зайн уралдаан уяачдын холбоо НҮТББ-тай хамтран Монгол улсад морин тойруулга ойрын зайн уралдааныг үүсгэн хөгжүүлэх, мэргэжлийн унаач бэлтгэх сургалт зохион байгуулах, хурдан морьдын дуудлага худалдаа явуулах чиглэлээр хамтран ажиллахаа. Монгол Адуу нийгэмлэгтэй Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан	30%

							“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хүй 7 худаг”-т мод үргүүлгийн газар байгуулах, Ардын хувьсгалын түүхт 100,101 жилийн хүрээнд 20000 морьтон ардын баярын жагсаал зохион байгуулах, Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Car Cinema” буюу автомашинтай үзвэр үйлчилгээг үзүүлэх зэрэг ажлыудыг зохион байгуулахаар хамtran ажиллах санамж бичиг байгуулахаар төлөвлөн, бэлтгэл ажил хангагсан байсан боловч дээрх төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй учир хэрэгжээгүй байна.	
8.3.	Мэргэжлийн болон Үндэсний спорт хороодтой 2022 онд хамtran зохион байгуулах тэмцээн уралдаан, төсөл хөтөлбөр, шинэ санал санаачилга боловсруулан, хамtran ажиллах санамж бичиг байгуулах.		Санамж бичгийн тоо	0	5	Монголын Үндэсний морин уралдаан уяачдын холбоо, Монголын Дугуйн холбоо ТББ гэх мэт мэргэжлийн болон Үндэсний спорт хороодтой 2022 онд хамtran зохион байгуулах тэмцээн уралдаан, төсөл хөтөлбөр, шинэ санал санаачилга боловсруулан, хамtran ажиллах санамж бичиг байгууллаа.	70%	
8.4.	Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын дүрмээр хулээсэн чиг үүргийн хүрээнд Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг бүрэн хангаж, шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх		Хэрэгжилтийн хувь	60%	100%	Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг бүрэн хангахад шаардагдах төсвийн төслийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанад хүргүүлэн ажилласан бөгөөд 145,9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Батлагдсан төсвийн дагуу баяр наадмын бэлтгэл ажлыг бүрэн хангаж баяр наадмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлсэн.	100%	
ЕС.БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:								
9.1.	Ардын хувьсгалын 100, 101 жил Үндэсний Их Баяр		Батлагдсан төсвийн	217,3	2,500,0	Үндэсний их наадмын бэлтгэл ажлын хүрээнд шаардагдах зардалд 2,5 тэрбум	100%	

	Наадмын бэлтгэл ажлын шаардлагатай төсөв боловсруулж батлуулах		ХЭМЖЭЭ/САЯ.ТӨГ/			ТӨГРӨГИЙН САНАЛ ХУРГУУЛСЭН БОЛОВЧ УЛС ОРНЫ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛААС ШАЛТГААЛЖ 145,9 САЯ ТӨГРӨГӨӨР БАТЛАГДСАН.	
9.2.	Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган ажиллах, албадуудын хийх ажлыг тодорхойлж эзэнжүүлэн, баяр наадмын салбар хороод холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах. Баяр наадмын тайлан гаргаж баяр наадмын комисст хүлээлгэн өгөх.		ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ	60%	100%	Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөөнд 71 ажлыг төлөвлөж, албадуудын хийх ажлыг тодорхойлж эзэнжүүлсэн. Баяр наадмын салбар хороодын хуралд 4 удаа оролцож холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллав. Үндэсний их баяр наадмын тайлан гаргаж холбогдох байгууллагуудад хургуулж үлдэгдэл санхүүжилтийг бүрэн авч ажилласан.	100%
9.3.	Зам талбай, Авто зогсоолын хэвийн ажиллагааг хангаж, засвар, цэвэрлэгээний ажлыг тогтолцоулж гүйцэтгэх	1,3	Засвар цэвэрлэгээний ажлын тоо, чанар	24	36	Зам талбай, авто зогсоолын хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байгаа бөгөөд байгууллагын эзэмшилийн 2,7 км зам талбайн хагарч гэмтсэн аспалтан замыг 2021 онд мэргэжлийн байгууллагаар засварлуулсан бөгөөд авто замын бүрэн бүтэн байдал, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж 7 хоног тутам хянайлт тавьж ажиллаж байна. Нийт 6000 автомашины зогсоол, морь барианы орчмын 30 га талбайг 14 хоног тутам хуваарийн дагуу цэвэрлэж эхний 10 сарын байдлаар нийт 38 удаа цэвэрлэгээ хийж 22,5 тн хогийг аниж зайлцуулсан. Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлын хурээнд явган хүний зам, экобусны замуудын эвдрэл гэмтлийг бүрэн засварлаж наадамчдын ая тухтай зорчих боломжийг бүрдүүлсэн. Хуй долоон худагт зохион байгуулагдсан баяр наадам болон бусад арга хэмжээнүүдийн үед зам талбайн хэвийн байдлыг хангаж ажиллав.	100%

9.4.	Инженерийн шугам сүлжээ, нийтийн бие засах газруудын хэвийн ажиллагааг хангаж, шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийх	Засвар цэвэрлэгээний ажлын тоо,чанар	24	40	Хүй 7 худаг дах оффисын байрны сантехникийн шугам сүлжээний хэвийн байдалд хуваарийн дагуу хяналт тавьж ажилласан. Эвдэрч гэмтсэн крант 3, холбоос 5-ыг сольж,хэвийн байдлыг хангасан. Урын зуухны хэвийн ажиллагааг хангаж халаалтын улиралд З эзлжээр голч ажиллуулж, агуулахад хадгалагдаж байгаа эд хөрөнгийг хэвийн температурт хадгалах нөхцлийг бүрдүүлсэн. Нийтийн бие засах газруудын хэвийн ажиллагааг ханган ажиллахаар Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажилд шаардагдах зардлын төсөвт бие засах газруудын засвар үйлчилгээнд шаардагдах 18,0 сая төгрөгийг батлуулсан бөгөөд шаардлагатай засварын ажлыг хийж гүйцэтгэн ажиллав. Өнгөрсөн онд шинээр авсан 10 ш бие засах газрыг байршуулж холбогдох засвар үйлчилгээг хийсэн. Хүй 7 худагт зохион байгуулагдсан Үндэсний их баяр наадам, Хүрээ цам даншиг наадам, Үндэсний спортын 7 дугаар наадам зэрэг томоохон арга хэмжээнүүд болон бусад 8 арга хэмжээнд нийтийн бие засах газруудыг ажиллуулж гарсан эвдрэл гэмтлийг тухай бүр засварлаж ажилласан. Баяр наадмын өдрүүдийн нийтийн бие засах газруудын цэвэрлэгээ үйлчилгээнд нийт 69 хүнийг хөлсөөр ажиллуулах гэрээгээр авч ажиллуулсан.	100%
9.5.	Тохижилтын ажлуудын бүрэн бүтэн байдлыг хангаж, өмч хөрөнгийг хамгаалах	Засвар цэвэрлэгээний ажлын тоо,чанар	30	60	Байгууллагын дүрмээр жүлээсэн үүргийн дагуу баяр наадам зохион байгуулах, зам талбай, авто зогсоол, түүний эд хөрөнгө, инженерийн шугам сүлжээ, техник тохижилтын бүрэн бүтэн байдал, ашиглалтыг хариуцан өмч хөрөнгийн бүрэн	100%

							бүтэн байдлыг ханган хяналтын карт хөтлүүлж байна. Түрээс үйлчилгээнд гарах угсардаг сандал, бусад эд хөрөнгийг ачих, буулгах, угсрах, сууринуулах, хураах зэрэг ажлуудыг хийж, актлах, засварлах шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг гарган ажилласан.	
9.6.	Техник төхөөрөмжүүдийн ажиллагааг хангаж, үйлчилгээг хийх	тоног хэвийн засвар	1,0	Засвар үйлчилгээний ажлын тоо,чанар	32	40	Ургал засвар хийх төсөв тавигдаагүй. Үндэсний их баяр наадмын үеэр Старекс, элентра, крантай машины тос, тосолгооны материалыг 9,7 сая төгрөгөөр сольсон. Засгийн газрын 2022.5.25-ны өдрийн Дугаар 204, Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан Элентра маркийн суудлын автомашиныг "Засгийн газрын авто бааз" УТҮГ-Т шилжүүлсэн. Газрын хөрөнгөд бүртгэлтэй 10 тээврийн хэрэгслийн ашиглалтын байдалд өдөр тутам хяналт тавьж бэлэн байдлыг ханган ажилласан.	100%
9.7	Тээврийн хэрэгслүүдийг татвар, оношилгоо, даатгалд бүрэн хамруулж, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх		8,3	Хэвийн ажиллагааг хангуулсан тээврийн хэрэгслийн тоо	11	11	Байгууллагад бүртгэл бүхий 11 тээврийн хэрэгслийг татвар, оношилгоо, даатгалд бүрэн хамруулсан. Энэ ажилд 1,650.0 төгрөг зарцуулсан.	100%
9.8	Тээврийн хэрэгслүүдийг шаардагдах шатах тослох материалыар тасралтгүй хангаж, шатахууны зарцуулалтын хяналтыг сайжруулах		29,9	Шатахууны зардлын хэмжээ	17,1	20	2022 оны 10 сарын байдлаар 20 сая төгрөгийн шатахуун, тос таслох материалын зарцуулалт хийгдсэн бөгөөд шатахуун зарцуулалтын байдалд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.	100%

9.9	Цахилгаан хангамжийн хэвийн байдлыг хангаж, өр авлагагүй ажиллаж, засвар үйлчилгээг хийх	35,3	Засвар үйлчилгээний ажлын тоо,чанар	32	16,8	Цахилгаанаас үүдэлтэй осол, гал түймэр гарахаас урьдчилан сэргийлж, цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжүүдэд өдөр тутам хяналт тавин эвдрэл гэмтлийг тухай бүр засварлан ажиллав. Цахилгаан хангамжийн хэвийн байдлыг хангаж хагас жилийн цахилгааны төлбөрийг өр авлага үүсгээгүй тогтсон хугацаанд төлбөрийг барагдуулж ажилласан. Тайлант оны 10 сарын байдлаар гэрэл, цахилгааны төлбөрт 35,3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 16,8 сая төгрөг зарцуулсан.	90%
9.10	Шуудан холбоо, интернэтийн хэвийн ажиллагаат хангаж, өр авлагагүй ажиллах	3,2	Хэвийн ажиллагаа хангагдсан байдал	80%	100	Шуудан холбоо интернэтийн төлбөрийг сар бүрийн 25-ны өдөр барагдуулж ажилладаг бөгөөд шуудан холбоо, интернэтийн зардлын төсөвт 3,2 сая төгрөгээр батлагдсанаас 2,1 сая төгрөгийг зарцуулж өргүй ажиллаж байна.	100%
66	Нийт	617,8 сая.төг			494,9 сая.төг	Энэ онд 85,0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 11 сарын байдлаар 117,2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь орлогыг 137,8%-аар давж биелүүлсэн байна.	93.9%

ХЯНАСАН:
 ДАРГА 
 А.ОДБАЯР
 НЭГТГЭЖ БОЛОВСРУУЛСАН
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮЧЭЛГЭЭ ХАРИУЦСАН
 МЭРГЭЖИЛТЭН  Ц.ЛХАМЖАВ
Д. Манжав